

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2024.10...сарын...09.....

№ 7/28

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг  
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 болон Эм жи эл акуа ХК-ийн дүрмийн 7.26 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эм жи эл акуа ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн санал авсан С.Алтантуяаг сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Алтантуяад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С. АЛТАНТУЯА

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024.10...сарын...09....

№ Т/29

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл болон Эм жи эл акуа ХК-ийн дүрмийн 7.21.18 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

**А. Аудит эрсдлийн хороо:**

1. С.Санасэр (ТУЗ хараат бус гишүүн )
2. О.Сансар /Shansier/ (ТУЗ ердийн гишүүн )
3. Ч.Анхбаяр (ТУЗ хараат бус гишүүн), Хорооны дарга

**Б. Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо**

1. Ч.Анхбаяр (ТУЗ хараат бус гишүүн )
2. С.Санасэр (ТУЗ хараат бус гишүүн ), Хорооны дарга
3. Б.Ундрал (ТУЗ ердийн гишүүн )

**В. Стратеги, бизнес хөгжлийн хороо**

1. Х.Тэгшээ (ТУЗ ердийн гишүүн )
2. С.Санасэр (ТУЗ хараат бус гишүүн )
3. С.Алтантуяа (ТУЗ хараат бус гишүүн )
4. Д.Басандорж (ТУЗ хараат бус гишүүн )
5. М.Дөлгөөн (ТУЗ ердийн гишүүн ), Хорооны дарга

**Г. Хөрөнгө оруулагчдын харилцааны хороо**

1. Л.Билгүүн (ТУЗ ердийн гишүүн ), Хорооны дарга
2. Б.Ундрал (ТУЗ ердийн гишүүн )
3. М.Дөлгөөн (ТУЗ ердийн гишүүн )

2. Хороодыг хууль журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулан, хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байхыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С. АЛТАНТУЯА